БАТЛАВ
“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ш.ОТГОНБАЯР

Ажлын хувцас /өвөл, зуны/ худалдан авах ажлын даалгавар

Үндэслэл:

ХАБЭА-н тухай хуулийн 15-р зүйлийг мөрдлөг болгон Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутагт байрлах “Тавантолгой” ХК-ийн уурхайн нийт ажилчдыг ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас хэрэгслээр хангах.

Зорилго:

Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, хүний эрүүл мэндэд тохирсон ажлын хувцас үйлдвэрлэн ажиллах чадамж бүхий хуулийн этгээдийг сонгон шалгаруулах.

Хамрах хүрээ:

Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо багийн нутагт орших Тавантолгой ХК-ийн нийт ажилчид.

Хамрах хугацаа:

Ажлын хувцас /өвөл, зуны/ худалдан авах гэрээг 3 жилийн хугацаатай байгуулан ажиллах ба санхүүжилт тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд байна.

АЖЛЫН ХУВЦАСНЫ ЗАДАРГАА

№	Хамгаалах хэрэгслийн нэр	Тоо хэмжээ		Хэмжих нэгж
		Эр	Эм	
1	Зуны хүрэм	220	80	Ширхэг
2	Зуны өмд	220	80	Ширхэг
3	Зуны ажлын цамц	220	80	Ширхэг
4	Ажлын бомбер	220	80	Ширхэг
5	Зуны поло подволк	220	80	Ширхэг
6	Өвлийн хүрэм	220	80	Ширхэг
7	Өвлийн өмд	220	80	Ширхэг
8	Зузаан цамц	220	80	Ширхэг

Ерөнхий шаардлага:

1. Тухайн ажлын хувцас нь MNS ISO 13688:2000 стандартын шаардлагуудыг хангасан байна;
2. Материал нь мэргэжлийн байгууллагын тодорхойлолт (дүгнэлт), шинжилгээний бичиг зэрэг дагалдах баримт бичигтэй байна;
3. Хөлөргөж чийг татахаас сэргийлсэн агаар сэлгэлт сайтай, амьсгалдаг материал эсвэл технологи ашигласан байна;
4. Ажлын хувцасны бүх оёдлыг 1 см-т 4-5, дотор холбох, хавсарсан оёдлыг 1см-т 3-4 хатгацтайгаар, сайн чанарын 100% даавуун утсаар оёно. Залгаас болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийж өгсөн байна;
5. Ажлын хувцас бүр гэрэл ойлгогч цацруулагчтай байх ба оёсон байна;
6. Угаалгын градус +30^{0}С-аас +60^{0}С-д угааж, +60^{0}С-аас +71^{0}С-д хатаахад өнгө болон дотор материалын агшилт суналт доорх шаардлагыг хангасан байна;
7. Угаалга цэвэрлэгээний дараа агшиж (агшилт суналт нь анхны хэмжээний 5%-иас ихгүй) сунахгүй буюу өмсгөлийн анхны хэмжээ болон хувцасны өнгө өөрчлөгдөхгүй байна (Угаалтаар агшиж, сунасан тохиолдолд ажлын хувцсыг бүгдийг солино);
8. Ажлын хувцсанд угаалга, арчилгааны шошго, хувцасны хэмжээ, үйлдвэрлэгчийн нэр, арчилгааны заавар болон бусад шаардлагатай мэдээллийг хувцас тус бүрд оёж тогтоосон байна;
9. Ажлын хувцас нь эрэгтэй, эмэгтэй загвартай байна. Биеийн анатоми хэлбэрт тохирсон байна;
10. Эрэгтэй 46,48, 50, 52, 54, 56, 58, 60, 62, 64; Эмэгтэй 42, 44, 46, 48, 50, 52, 54 гэсэн хэмжээтэй байх ба хувцасны хэмжээ тус бүрийг Захиалагчаас өгсөн чац, хэмжилтийн хүснэгтийн дагуу үйлдвэрлэнэ;
11. Захиалагчид нийлүүлэх бараа нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согогүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна;

Тусгай шаардлага

1. Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байх. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байхаас гадна угаалга цэвэрлэгээ, индүүдлэгт агшиж, сунахгүй байх, хүний биед харшлахгүй байх;

2. Ус, тос, масло нэвтрүүлэхгүй;
3. Төмөр буюу металл гадаргуутай хүрэлцэх үед хувцас нь цахилгаанжихгүй, үрэлтэд гэмтэх, цооролт өгөхгүй;
4. Ажлын үед шаардлагатай багаж хийх халаастай байх. Дээшээ авирах болон ажилтан суух болон бөхийх үед хөдөлгөөнд саад болохооргүй байхаас гадна өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх бололцоотой байна;
5. Цахилгаанжихгүй, болзошгүй цахилгаан нумалтын түлэгдэлт, галын үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй. Хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуун материалаар хийгдсэн байх;
6. Хязгаарлагдмал ажлын талбай буюу хөдөлгөөнтэй машин техник, элементүүдэд ороолдохгүй хийцтэй байх;
7. Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар ханцуй өмдний түрий хэсгээр гэрэлтдэг гэрэл ойлгогч оруулгатай байна;
8. Гэрэл ойлгогч оруулгын өнгө-саарал;
9. Хувцасны размер таарахгүй тохиолдолд нийт хувцасны тооны 20%-д размерын өөрчлөлт хийх боломжтой байна;
10. Үйлдвэрлэлийн алдаанаас хамаарч эвдрэл гэмтэл үүссэн тохиолдолд засварлах ажлыг гэрээ байгуулсан ААН 100% сэргээн засварлаж өгнө;
11. Зуны улиралд агааржуулах болон хөлс зайлуулах нөхцлийг хангах зорилгоор суга эсхүл нуруу хэсэгт салхи нэвтрэх торон хэсгийг оруулж болно;
12. Размер таарахгүй тохиолдолд гүйцэтгэгч тал компанийн байранд ирж засварлах ажлыг зохион байгуулна;
13. Хувцасны өнгө, загварыг гүйцэтгэгч талтай харилцан зөвлөлдсөний дүнд гаргана;

Хүснэгт 1. Зуны хувцасны багц

1.1	Материал	1. Срочка – 100% хөвөн давуу 2. Хүрэм – 65% хөвөн даавуу, 35% полистер; 3. Өмд – 65% хөвөн даавуу, 35% полистер;
1.2	Чанар	Хүний биеийг гаднын таагүй нөлөөнөөс бүрэн хамгаалах бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй
		Өнгө ба дотор материал нь угаахад агшдаггүй, будаг гардаггүй, эдэлгээний явцад өнгөн хэсэгт бүрзийлт үүсдэггүй, гаднын механик үйлчлэлд тэсвэртэй, шатамхай биш, дулаан алдахгүй, оёдол даах чадвартай байна;
		Залгаас болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийсэн байна;
		Бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна;
1.3	Баглаа боодол	Тээвэрлэхэд тохиромжтой, ус чийг, гаднын нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын сав, баглаа боодолтой байна;
1.4	Хүрэм	Зуны улиралд өмсөх хувцас нь +5^{0}C +30^{0}C хүртэлх температурт өмсөхөөр зориулагдсан байна;
		Хувцас бүрт цацруулагч буюу харанхуйд гэрэл ойлгогч хийсэн байна. Гэрэл ойлгогч нь 50 мм өргөнтэй байна. Энгэр болон ар нуруунд гэрэл ойлгогч туузыг хөндлөн оёно;

		Хүрмийн бүсэлхийн хэсэгт салхи орохоос хамгаалсан бүстэй байна;
		Хүрэм хөдөлгөөн хийхэд саад болохооргүй шингээлтийг хийж өгсөн байна;
		Хүрмийн баруун энгэрт станц тогтоох 2х5 см хэмжээтэй тогтоогч оёно;
		Хүрэм нь салхи орохоос хамгаалсан босоо захтай байх ба зах нь дээгүүрээ цахилгаантай салдаг юүдэнтэй байна. Юүдэн нь размер тааруулагчтай байна;
		Хүрмийн урд талд хормой хэсэгтээ хөндийрүүлэгчтэй 22х19 см хэмжээтэй, тагтай ил халаастай, энгэртээ өргөн нь 10 см-ээс багагүй гар хийх чөлөөтэй ташуу халаастай байна;
		Хүрэм нь ар нуруу, цээж, суганы хэсэгт хөлрөхөөс хамгаалсан торон (торон дотор нь өмсөж, тайлахад саад болохооргүй, сунахааргүй) дотортой байна;
		Ханцуйны хагалбар 18-20 см байх бөгөөд хагалбар нь далд буюу хоорондоо битүү холбоостой байна;
		Хүрмийн урт нь нуруу ил гарахааргүй ташаан толгой давсан байна;
		Хүрмийн энгэрийн дээд талд 2 талдаа кноп бүхий тагтай ил халаастай байна. Зүүн энгэрийн халаасанд бал, үзгийн нэмэлт таславч оёж өгсөн байна;
		Хүрэм цахилгаантай задгай энгэртэй, цахилгаанаа дарсан кноп (сайн чанарын) бүхий хаалттай, цахилгаан бат бөх байх ба угаалгад тэсвэртэй материалаар хийгдсэн байна;
1.5	Ажлын өмд	Өмдний ташаа хэсэгт далд халаастай, өмд нь гуяны гадна талд хөндийрүүлэгчтэй, зангуу бүхий тагтай 2 ил халаастай байна;
		Өмд хөндийрүүлэгчтэй халааснуудын дээд үзүүрийн ирмэгийг гадагш болохооргүйгээр их биед даруулж оёно;
		Арын суудал, өвдөг хэсэгт элэгдлээс хамгаалсан давхарлагаа ширээстэй хийгдсэн байна;
		Өмд гуяны гадна талд хөндийрүүлэгчтэй, зангуу бүхий тагтай ил халаастай байна. Хэмжээ: 18х18 см, хөндийрүүлэгчийн өргөн 2.5 см
		Өмдний шилбэ хэсэгт гэрэл ойлгогч туузтай (5 см) байна;
		Өмд нь шуумгийн доод талд хэмжээ тохируулах зориулалттай наалдагч даруулгатай байна. Шуумаг хэт өргөн биш шулуун загвартай байна;
		Хос эд ангийн хэмжээ, байрлал нь адил хэмжээтэй, материалын үндсэн утасны чиг (нэхээс) зөв байна;
		Өнгө үзэмжтэй, хөнгөн, өмсөхөд биед эвтэйхэн байна;
1.6	Ажлын цамц	Хөдөлгөөн хийх үед гар чөлөөтэй хөдлөх нөхцөлийг хангах үүднээс цамцны ханцуйн мөрний залгаас хэсэгт ар талын эсгүүрийн өргөн нь урд талын эсгүүрээс 2 см - 3 см урт байна;
		Цамцны захны үзүүр ба энгэр, халаас, ханцуй товчтой байна;

		Ханцуйны хагалбар 18 см-20 см байх ба ханцуйны үзүүр, дунд хэсэгт товчтой, дээш шууж товчлоход саад болохооргүй хангалттай өргөн, мөн сойж товчлох бүчтэй байна;
		Цацруулагч буюу гэрэл ойлгогч нь ханцуй болон цээж хэсэгт 3 см, бүсэлхий хэсгээр 5 см өргөнтэй байна. Энгэр болон нуруунд гэрэл ойлгогч тууз параллелиар хоорондоо 18 см зайтай байна;
		Суганд болон ар нурууны далны түвшинд салхивч тортой байна;
		Цамцны энгэрийн ил халаас нь 12-14 см х 14-16 см хэмжээтэй, амсар дарагч 12-14 см х 5-7 см товчлогддог байна. (цамцны харьцаанд тааруулан хийх)
		Ханцуйн эмжээр (манжетик) 5 см-ээс багагүй байна;
		Цамцны урт нь нуруу ил гарахааргүй ташаан толгой давсан байна;
		Хос эд ангийн хэмжээ, байрлал нь адил хэмжээтэй, материалын үндсэн утасны чиг (нэхээс) зөв байна;
1.7	Бомбер	Хавар, намрын улиралд өмсөх хувцас нь +5^{0}С +30^{0}С хүртэлх температурт өмсөхөөр зориулагдсан байна;
		Хувцас бүрт цацруулагч буюу харанхуйд гэрэл ойлгогч хийсэн байна. Гэрэл ойлгогч нь 5-10 мм өргөнтэй байна. Энгэр болон ар нуруунд гэрэл ойлгогч туузыг хөндлөн оёно;
		Бомберын зах хэсэгт салхи бороноос хамгаалсан малгайтай байна;
		Бомбер нь ажилтан хөдөлгөөн хийхэд саад болохооргүй шингээлтийг хийж өгсөн байна;
		Бомборын баруун ханцуй хэсэгт үзэг, бал тогтоох халаастай байна;
		Малгайны гол сойлт хийж өгнө. Каскгүй үед өмсөхөд арагш нь болгох зориулалттай;
		Бомберны дотор утас болон тэмдэглэл хөтлөх дэвтэр хадгалах халаастай байна;
		Бомберын дотор хэсэг нь хөлөргөхгүй, хайрахгүй материалаар хийгдсэн байна;
		Бомберын доод хэсэг нь салхи шороонд дэрвэхгүй байх резинэн материалаар хийгдсэн байна;
		Хөдөлгөөн хийх үед гар чөлөөтэй хөдлөх нөхцөлийг хангах үүднээс бомберны ханцуйн мөрний залгаас хэсэгт ар талын эсгүүрийн өргөн нь урд талын эсгүүрээс 2-3 см урт байна;
		Цацруулагч буюу гэрэл ойлгогч нь 5 см-ийн өргөнтэй хөндлөн байна;
		Бомберын урд хэсэгт ташуу халаастай байх ба бээлийтэй гар орохоор зайтай байна.
		Бомберын баруун энгэрт станц тогтоох 2х5 см хэмжээтэй тогтоогч оёно;
		Бомберын урт нь нуруу ил гарахааргүй ташаан толгой давсан байна;
		Бомберын ханцуй хэт өргөн биш стандартын дагуу байна. Ханцуй болон бомберын хормой 5 см-ээс багагүй манжетиктай байна;
		Бомберын цахилгаан бат бөх байх ба угаахад тэсвэртэй материалаар хийгдсэн байна;
		Өнгө үзэмжтэй, хөнгөн, өмсөхөд биед эвтэйхэн байна;

		Өнгө ба дотор материал нь угаахад агшдаггүй, будаг гардаггүй, дулаан алдахгүй, оёдол даах чадвартай байна;
		Залгаас болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийсэн байна;
1.8	Зуны поло подволк	Хөдөлгөөн хийх үед гар чөлөөтэй хөдлөх нөхцөлийг хангах үүднээс цамцны ханцуйн мөрний залгаас хэсэгт ар талын эсгүүрийн өргөн нь урд талын эсгүүрээс 2-3 см урт байна;
		Цамцны ханцуйны эмжээр (манжетик) 5 см-ээс багагүй нимгэн резинэн байна;
		Подволк поло загвартай байх бөгөөд ханцуй, доод хэсэг давхар эмжээртэй байна;
		Цацруулагч буюу гэрэл ойлгогч нь урд мөр, ханцуй хэсэгт 3 см, ар нуруунд 5 см өргөнтэй хөндлөн байна;
		Углаж өмсдөг загвартай, захны ухлаадас 15 см ихгүй 2-3 товчтой байна;
		Цамцны энгэрийн зүүн талд логоны доод хэсэгт ил халаас нь 12-13см х 13-14 см хэмжээтэй, халаасанд бал, үзгийн нэмэлт таславч оёж өгсөн байна;
		Поло подволкын урт нь нуруу ил гарахааргүй ташаан толгой давсан байна;
1.9	Лого	Компанийн таних тэмдэг, лого зүүн энгэрт байрлана. 6х5 хэмжээтэй байна;
		Байгууллагын нэрийг нурууны хэсэгт 5 см өндөртэй том үсгээр оёсон байна;
1.10	Загвар	Өвлийн өмд, хүрэм эрэгтэй, эмэгтэй загвартай байна;
		Бомбер нь эрэгтэй эмэгтэй ижил загвартай байна;

1.11	**Хэмжээ, размер**	**42**	**44**	**46**	**48**	**50**	**52**	**54**	**56**	**58**
	Цээж	84	88	92	96	100	104	108	112	116
	Өндөр	160	164	168	171	177	180	182	184	186
	Бэлхүүс	72	76	80	84	88	92	98	102	108
	Гарын урт	57	58	59	60	61	62	63	64	65
	Хөлний урт	72	74	76	78	79	80	81	82	83

Тайлбар: Дээр дурдсан хэмжээс, хүлцлүүд нь зөвхөн лавлах баримжаа хэмжээ гэж тооцно. Тухайн ажлын тусгай хувцсыг дотуур өмд болон ажлын цамцан дээр өмсөхөөр тооцож зохион бүтээлтээ хийнэ. Мөн түүнчлэн туранхай, том биетэй болон илүүдэл жинтэй хүний хувцас шаардлагатай тохиолдолд тусгайлан хэмжээ авахуулж үйлдвэрлүүлнэ.

Хүснэгт 2. Өвлийн хувцасны багц

1.1	Материал	1. Хүрэм – 65% хөвөн даавуу, 35% полистер; 2. Өмд – 65% хөвөн даавуу, 35% полистер;
1.2	Чанар	Ажлын хувцасны чанар нь хэрэглээний болон технологийн тодорхойлолтод хэрхэн нийцсэн, хүний биед таарч байгаа байдлаар тодорхойлно;
		Өнгө ба дотор материал нь угаахад агшдаггүй, будаг гардаггүй, дулаан алдахгүй, оёдол даах чадвартай байна;

		Залгаас болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийсэн байна;
		Бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна;
1.3	Баглаа боодол	Тээвэрлэхэд тохиромжтой, ус чийг, гаднын нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын сав, баглаа боодолтой байна;
1.4	Өвлийн хүрэм	Өвлийн улиралд өмсөх хувцас нь -25^{0}C - 30^{0}C хүртэлх температурт өмсөхөөр зориулагдсан байна;
		Хувцас бүрт цацруулагч буюу харанхуйд гэрэл ойлгогч хийсэн байна. Гэрэл ойлгогч нь 50 мм-ийн өргөнтэй байна. Энгэр болон ар нуруунд гэрэл ойлгогч туузыг хөндлөн оёно;
		Хүрмийн бүсэлхийн хэсэгт салхи орохоос хамгаалсан бүстэй байна;
		Хүрэм хөдөлгөөн хийхэд саад болохооргүй шингээлтийг хийж өгсөн байна;
		Хүрмийн баруун энгэрт станц тогтоох 2х5 см хэмжээтэй тогтоогч оёно;
		Хүрэм нь захнаас үргэлж юүдэнтэй буюу “аляска” загвартай байна;
		Хүрмийн зах цахилгаандсан тохиолдолд хүзүү барихааргүй чөлөөтэй байна;
		Юүдэн салдаг цахилгаантай байна;
		Малгайны гол сойлт хийж өгнө. Каскгүй үед өмсөхөд арагш нь болгох зориулалттай;
		Хүрмийн урд талд хормой хэсэгтээ хөндийрүүлэгчтэй 22х19 см хэмжээтэй, тагтай ил халаастай, энгэртээ өргөн нь 10 см-ээс багагүй гар хийх чөлөөтэй ташуу халаастай байна. Энгэрийн халаасыг өвлийн нөхцөлд тохируулан дотор талд цахилгаантай хийнэ;
		Хүрмийн ханцуй хэт өргөн биш стандартын дагуу байна. Ханцуй нь 50 мм-ээс багагүй далд манжаткатай үргэлж байна;
		Ханцуйн манжатка ханцуйтай үргэлж оёдолтой байх ба урагш хойш татлахааргүй байна;
		Хөндийрүүлэгчтэй халааснуудын дээд үзүүрийн ирмэгийг гадагш болохооргүйгээр их биед даруулж оёно;
		Хүрмийн урд талд хормой хэсэгтээ хөндийрүүлэгчтэй 22х19 см хэмжээтэй, тагтай ил халаастай, энгэртээ өргөн нь 10 см-ээс багагүй гар хийх чөлөөтэй ташуу халаастай байна. Энгэрийн халаасыг өвлийн нөхцөлд тохируулан дотор талд цахилгаантай хийнэ;
		Хүрмийн ханцуй хэт өргөн биш стандартын дагуу байна. Ханцуй нь 50 мм-ээс багагүй далд манжаткатай үргэлж байна;

		Ханцуйн манжатка ханцуйтай үргэлж оёдолтой байх ба урагш хойш татлахааргүй байна;
		Цахилгаан бат бөх байх ба 90°С-т угаахад хайлахгүй материалаар хийгдсэн байна;
		Энгэрийн цахилгааны дотор талд жавар хаасан дулаалгатай планктай байна;
1.5	Өвлийн өмд	Өмдний ташаа хэсэгт далд халаастай байна;
		Өмдний бүс хэсэг нь нуруу болон бүсэлхийн хэсгээр дулаан байхад зориулсан өндөрсгөсөн манжаткатай байна. Урд тал нь 2 ширхэг товчтой байна;
		Өмдний өндөрсгөсөн манжатка нь 13 см-ээс багагүй, нуруунд таарсан танаастай байна;
		Өмд, нь гуяны гадна талд кноп бүхий тагтай, хөндийрүүлэгчтэй ил халаастай байна. Хэмжээ: 18х18см, хөндийрүүлэгчийн өргөн 2.5 см
		Өмд, нь шуумагтаа битүү хагалбартай, цахилгаантай байна. Шуумгийн өргөн хэт өргөн биш 20-23 см байна;
		Хөндийрүүлэгчтэй халааснуудын дээд үзүүрийн ирмэгийг гадагш болохооргүйгээр их биед даруулж оёно;
		Өмдний ташаа хэсэгт далд халаастай байна;
		Өмдний бүс хэсэг нь нуруу болон бүсэлхийн хэсгээр дулаан байхад зориулсан өндөрсгөсөн манжаткатай байна. Урд тал нь 2 ширхэг товчтой байна;
		Өмдний өндөрсгөсөн манжатка нь 13 см-ээс багагүй, нуруунд таарсан танаастай байна;
		Өмд, нь гуяны гадна талд кноп бүхий тагтай, хөндийрүүлэгчтэй ил халаастай байна. Хэмжээ: 18х18см, хөндийрүүлэгчийн өргөн 2.5 см
		Өмд, нь шуумагтаа битүү хагалбартай, цахилгаантай байна. Шуумгийн өргөн хэт өргөн биш 20-23 см байна;
		Цахилгаан бат бөх байх ба 90°С-т угаахад хайлахгүй материалаар хийгдсэн байна;
		Арын суудал, өвдөгний элэгдэлээс хамгаалсан давхарлагаатай хийгдсэн байна;
		Өмдний шилбэ хэсэгт гэрэл ойлгогчтой 50 мм-ийн туузаар тойруулан давхарлаж оёсон байна;
		Үлгэрт өгөгдсөн шингээлт жигд зөв хийгдсэн байна;
		Хос эд ангийн хэмжээ, байрлал нь адил хэмжээтэй, материалын үндсэн утасны чиг /нэхээс/ үлгэрт өгөгдсөний дагуу зөв байна;
		Өнгө үзэмжтэй, хөнгөн, өмсөхөд эвтэй байна;
1.6	Зузаан цамц	Цамцны ханцуй суналттай манжетиктай (гарын шуу барихааргүй) байна.
		Цамц нь цахилгаантай задгай энгэртэй, цахилгаан нь бат бөх байх ба угаалгад тэсвэртэй материалаар хийгдсэн байна.

		Мөр, нурууны хэсгээр 3 см гэрэл ойлгогч хавчуургатай, ханцуй хэсэгт 3 см өргөнтэй гэрэл ойлгогчтой байна.
		Цамцны урд хэсэгт ташуу халаастай байх ба бээлийтэй гар орохоор зайтай байна.
		Цамцны зах 6 см босоо эргэдэггүй захтай байна.
		Цамцны хормойгоор хэмжээг тохируулагч чангалууртай байна.
		Өнгө үзэмжтэй, хөнгөн, өмсөхөд эвтэйхэн байна.
		Эмэгтэй цамц эмэгтэйчүүдийн анатомийн бүтцэд тохирсон тайлтай байна.
		Зүүн энгэр хэсэгт далд цахилгаантай халаастай байна
1.7	Лого	Компанийн таних тэмдэг, лого зүүн энгэрт байрлана. 6х5 см хэмжээтэй байна;
		Байгууллагын нэрийг нурууны хэсэгт 5 см өндөртэй, том үсгээр оёсон байна;
1.8	Загвар	Өвлийн өмд, хүрэм эрэгтэй, эмэгтэй загвартай байна;

1.9	**Хэмжээ, размер**	**42**	**44**	**46**	**48**	**50**	**52**	**54**	**56**	**58**
	Цээж	84	88	92	96	100	104	108	112	116
	Өндөр	160	164	168	171	177	180	182	184	186
	Бэлхүүс	72	76	80	84	88	92	98	102	108
	Гарын урт	57	58	59	60	61	62	63	64	65
	Хөлний урт	72	74	76	78	79	80	81	82	83

Тайлбар: Дээр дурдсан хэмжээс, хүлцлүүд нь зөвхөн лавлах баримжаа хэмжээ гэж тооцно. Тухайн ажлын тусгай хувцсыг дотуур өмд болон ажлын цамцан дээр өмсөхөөр тооцож зохион бүтээлтээ хийнэ. Мөн түүнчлэн туранхай, том биетэй болон илүүдэл жинтэй хүний хувцас шаардлагатай тохиолдолд тусгайлан хэмжээ авахуулж үйлдвэрлүүлнэ.

Зөвшөөрсөн:
Гүйцэтгэх захирал — Ш.Отгонбаяр

Танилцсан:
Захиргаа, удирдлагын газрын захирал — С.Идэрсүрэн

Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газрын захирал — Б.Нарантуяа

Уул, уурхай технологийн газрын захирал — Э.Болд-Эрдэнэ

Хянасан:
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга — Б.Содномцэрэн

Боловсруулсан:
Хөдөлмөрийн эрүүл ахуйч — Х.Оюу-Эрдэнэ